“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
**төрийн өмчит хувьцаат компани**



# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 2025


7058 4547

www.ees.energy.mn

Дорнод аймаг, Хэрлэн сум
1-р баг, Чойбалсангийн гудамж


АЛТАН ГАДАС ОДОНТ
ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ ТӨХК



# Үндсэн үйл **ажиллагаа**

Үндсэн үйл ажиллагааны хувьд манай компани цахилгаан, дулаан үйлдвэрлэх, түгээх, зохицуулалттай хангах, цахилгаан импортлох, эрчим хүчний тоноглолд засвар туршилт хийх, цахилгаан, дулааны эрчим хүчний тоолуур гүйдлийн трансформатор суурилуулах, засварлах зэрэг 9 тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг.

Дорнод, Сүхбаатар аймгийн 36 сум суурин газрын 33,601 айл өрх, 3,649 аж ахуйн нэгж, байгууллага, 17 уул уурхай, газрын тос олборлолтын компаниудыг 0.4, 6, 10, 15, 35, 110кВ-ын 3698,9 км агаарын болон кабель цахилгаан дамжуулах шугам, 507 ком дэд станцыг ашиглан цахилгаан эрчим хүч, Чойбалсан хотын 9,409 айл өрх, 936 аж ахуйн нэгж байгууллагыг 26,5 хос/км магистрал шугам ашиглан дулааны эрчим хүчээр хангаж байна. Мөн Төвийн бүс нь чадлын дутагдалд орсон, ЦДАШ-д гэмтэл, саатал гарсан үед Өндөрхааны хэрэглэгчдийг ЦЭХ-ээр хангаж байна.



# Агуулга

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН


01 УДИРДЛАГА, ХҮНИЙ НӨӨЦ ....................................................................7

02 ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИН ........13

03 ИХ ЗАСВАР, ТЗБАХ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ..........................................20

04 ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ...........................24

05 ЦАХИЛГААНААР ЗОХИЦУУЛАЛТАЙ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА.....32

06 САНХҮҮГИЙН ТАЙЛАН ........................................................................46

07 ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА...........................................................54

08 ИЛ ТОД ЁС ЗҮЙН БАЙДАЛ....................................................................58

09 НИЙГМИЙН АСУУДАЛ, СПОРТ ............................................................60

10 "ТЭР БУМ МОД" ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН ..........................................64



**Ө.ЖАРГАЛСАЙХАН**

"ДБЭХС" ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

## МЭНДЧИЛГЭЭ

“ДБЭХС” ТӨХК-ийн хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн удирдах зөвлөл, түнш байгууллагууд, нийт ажилтан албан хаагчид болон компанийн үйл ажиллагааг дэмжин ажилладаг байгууллагуудын хамт олонд талархал илэрхийлье.

2025 онд манай компанийн хувьд үйлдвэрлэлийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангахын зэрэгцээ 50 МВт-ын станцыг ашиглалтад хүлээн авч ажиллагаанд амжилттай явуулсан жил байлаа. Тайлант хугацаанд манай хамт олон хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн сахилга хариуцлагыг эрхэмлэн ажиллаж, Монгол Улсын цахилгаан эрчим хүчний нийт хэрэглээний 4.2 хувийг үйлдвэрлэн, Зүүн бүс нутгийг цахилгаан эрчим хүчээр, Чойбалсан хотын дулааны эрчим хүчний хэрэгцээг тасралтгүй, найдвартай ханган ажиллалаа. Мөн тоног төхөөрөмжийн ашиглалтын үр ашгийг дээшлүүлж, хүчин чадлын ашиглалтыг 50.2 хувьд хүргэв.

2025–2026 оны өвлийн их ачааллын үед станцын 7 зуух, 5 турбогенератор бүрэн хүчин чадлаар ажиллаж, 81.5 МВт хүртэлх ачааллыг найдвартай ханган ажилласан нь манай хамт олны хариуцлагатай, шуурхай ажиллагааны үр дүн байлаа.

Тайлант онд манай хамт олон нийт 378.0 сая кВт.цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж, өмнөх онтой харьцуулахад 81.9 сая кВт.цаг-аар өсгөсөн амжилт гаргасан бөгөөд энэ нь эрчим хүчний системийн найдвартай ажиллагаа, санхүүгийн тэнцэлд эерэг нөлөө үзүүлсэн үзүүлэлт боллоо. Мөн төлөвлөгөөт цахилгаан эрчим хүчний түгээлтийг 99.8 хувь, дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийг 104.1 хувь-иар тус тус биелүүлэн ажиллалаа.

Манай хамт олон эрчим хүчний салбарын тогтвортой, найдвартай ажиллагааг хангах хариуцлагатай үүргээ цаашид ч нэр төртэйгээр хэрэгжүүлж, 2026 онд төлөвлөсөн засвар, шинэчлэлийн ажлуудыг чанартай, хугацаанд нь гүйцэтгэн, ирэх өвлийн их ачааллыг амжилттай даван туулах бэлтгэлийг ханган ажиллах болно.

Та бүхэндээ эрүүл энх, аз жаргал, ажлын өндөр амжилтыг хүсэн ерөөе.



# Удирдлага, хүний нөөц

"Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК-ийн 34 хувийг Эрчист Монгол ХХК, 66 хувийг Эрчим хүчний яамны эзэмшилд байдаг ба Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний төлөөллийг Эрчим хүчний яам болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас хангаж байна. Төлөөлөн удирдах зөвлөл нь нийт 9 гишүүнтэй. Үүнээс Төрийн төлөөлөл 6, хараат бус 3 гишүүнтэй.

Төлөөлөн удирдах зөвлөл нь 2025 онд Эрчим хүчний сайдаас ирүүлсэн удирдамж, чиглэлийн дагуу 15 удаа цахимаар хуралдсан. Нийт 33 асуудал хэлэлцэж, 20 тогтоол, 13 тэмдэглэлээр шийдвэр гаргасан байна.



**О.ХУЯГЦОГТ**
Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга



**В.ДАРХАНБААТАР**
ТУЗ-ийн гишүүн



**Д.ОЮУНЧИМЭГ**
ТУЗ-ийн гишүүн



**Б.ЭНХТӨР**
ТУЗ-ийн гишүүн



**С.АНАР**
ТУЗ-ийн гишүүн



**Б.МӨНХБААТАР**
ТУЗ-ийн гишүүн



**И.АЛТАНСУВД**
ТУЗ-ийн хараат бус гишүүн



**Г.МӨНХБАЯР**
ТУЗ-ийн хараат бус гишүүн



**Э.ГАНБААТАР**
ТУЗ-ийн хараат бус гишүүн




# Бүтэц, орон тоо:

–

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 02 тоот тогтоолоор батлагдсан 7 хэлтэс, 1 салбар, 1 алба, 8 цехийн бүтэцтэй, 740 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна.

–

2025 оны байдлаар удирдлага 19, инженер техникийн ажилтан, албан хаагч 158, ажилтан 536 буюу нийт 713 ажилтан ажиллаж, 96.4 хувийн гүйцэтгэлтэй байна.

**Эрэгтэй**
**504**

**Эмэгтэй**
**209**

2025 онд сул чөлөөтэй ажлын байрны зарыг аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар болон компанийн цахим сайтаар нийт 56 удаа байршуулж, 147 ажил хайгч иргэнийг бүртгэн сонгон шалгаруулалт зохион байгуулсан.

Тайлант хугацаанд 61 хүн шинээр ажилд орсон бөгөөд өөрийн хүсэлт болон ажлын шаардлагын дагуу 79 ажилтны албан тушаалд өөрчлөлт орсон.




## Сургалт хөгжил:



Төлөвлөсөн 39 сургалт
Зохион байгуулсан 35 сургалт

Төлөвлөсөн 135,0 сая.төгрөг
Зарцуулсан 104,1 сая.төгрөг

Давхардсан тоогоор 1412 ажилтан хамрагдсан

Сургалт хөгжлийн бодлогын зорилго нь компанийн эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйл, хүний нөөцийн бодлогын хүрээнд байгууллага болон ажилтнуудад шаардлагатай сургалтын хэрэгцээг тодорхойлж, мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх, байгууллагын соёл зан үйлийг төлөвшүүлэх, сургалтын чанарыг тасралтгүй сайжруулан ажилтныг тогтмол хөгжүүлэхэд чиглэнэ. Энэ хүрээнд 2025 оны сургалтын төлөвлөгөөг өмнөх оны гүйцэтгэл, ажилтнуудын санал хүсэлт, судалгаа болон салбарын ижил төстэй байгууллагуудын туршлагад үндэслэн боловсруулж, гүйцэтгэх захирлаар батлуулан хэрэгжилтийг хангаан ажилласан.

| № | Он | Сургалтын тоо | Төлөвлөгөө /сая.төг/ | Биелэлт /сая.төг/ | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2023 он | 54 | 137,5 | 130,2 | 94.72% |
| 2 | 2024 он | 37 | 124,0 | 117,8 | 95.01% |
| 3 | 2025 он | 35 | 135,0 | 104,1 | 77,07% |

—

Тайлант онд Мэргэжлийн шалгалтын комисст 218 ажилтан шалгалт өгөхөөр төлөвлөснөөс 166 ажилтан зэрэг ахисан буюу жинхэлсэн байна.




# Хөдөлмөрийн харилцаа, тушаал шийдвэр:



—

2025 онд Гүйцэтгэх захирлын А буюу үндсэн үйл ажиллагаатай холбоотой 156 тушаал, Б буюу хөдөлмөрийн харилцаа, хүний нөөцтэй холбоотой 509 тушаал тус тус гарсан.



# Олон нийтийн ажил:

—



Дорнод аймгийн Хөлөнбуйр суманд гарсан гал түймрийн аюулд өртсөн малчдад туслах зорилгоор компанийн нийт ажилтнуудын дунд сайн дурын “Малчдад туслах аян”-ыг амжилттай зохион байгууллаа. Аяны хүрээнд 5.35 сая төгрөгийн мөнгөн хандив, 17 нэр төрлийн 1.47 сая төгрөгийн үнэ бүхий эд материал цуглуулж, нийт 6.83 сая төгрөгийн хандивыг Дорнод аймгийн Онцгой комисст хүлээлгэн өгсөн.

Алтан гадас одонт “Дорнод бүсийн эрчим хүчний систем” Төрийн өмчит хувьцаат компанийн техникийн болон эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд бодит хувь нэмэр оруулж, ажлын амжилт, бүтээлээрээ хамт олноо манлайлан ажилласан 2025 оны “Тэргүүний албан хаагч”-дыг шалгаруулсан.




| д/д | Номинаци | Овог нэр | Алба, хэлтэс, цех | Албан тушаал |
|---|---|---|---|---|
| 1 | Үйлчилгээний тэргүүний ажилтан | Ц.Нандин-Эрдэнэ | Зуухан цех | Техникийн туслах ажилтан |
| 2 | Борлуулалтын тэргүүний ажилтан | Ж.Энхсайхан | ЭХБХэлтэс | Борлуулалтын байцаагч монтёр |
| 3 | Тэргүүний жолооч | З.Базарваань | НҮХэлтэс | Автогражийн жолооч |
| 4 | Тэргүүний монтёр | Ц.Энхболд | Цахилгаан цех | Засварын монтёр |
| 5 | Тэргүүний засварчин | Ж.Бэхбат | НҮХэлтэс | Бэлтгэх хэсгийн засварчин |
| 6 | Тэргүүний машинч | Х.Цэцэгтуяа | Турбин цех | Машинч |
| 7 | Тэргүүний оператор машинч | Ц.Батцэцэг | ТДЦех | Конвейерийн ахлах машинч |
| 8 | Тэргүүний ээлжийн мастер | Ц.Батмөнх | Зуухан цех | Ээлжийн мастер |
| 9 | Тэргүүний албан хаагч | Г.Нарантуяа | СЭЗХэлтэс | Эдийн засагч |
| 10 | Тэргүүний ИТА | Е.Мөнхбат | Турбин цех | Цехийн дарга |
| 11 | Бүтээлч ажилтан | М.Отгонбаатар | ЦШС-ний цех | ДСХБ-ийн засварын монтёр |
| 12 | Шилдэг ажилтан | Г.Ариунболд | ЦШС-ний цех | АШЗ-ын монтёр |

# СИСТЕМИЙН ХЭМЖЭЭНД БОЛОВСРУУЛСАН ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧ

**378,0 сая.кВт.ц**

НИЙТ БОЛОВСРУУЛСАН

ТӨЛӨВЛӨЛТ

0,21%

**372,9 сая.кВт.ц**

ТҮГЭЭЛТ

ТӨЛӨВЛӨЛТ

0,2%



# Техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Эрчим хүчний сайдын 2025 оны 09 дүгээр сарын 23 ны өдрийн А/238 тоот тушаалаар баталсан 2025 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний үзүүлэлтийг мөрдөж ажилласан.

| д/д | Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2025 | | өсөлт/бууралт | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | төлөв | Гүйц | Дүн | Хувиар |
| 1 | ЦЭХ боловсруулалт | сая. кВтц | 386.3 | 378.0 | (8.3) | 97.9% |
| 2 | ДХЦЭХ | хувь | 14.0% | 14.2% | 0.0 | 98.9% |
| 3 | Нийт түгээлт ЦЭХ | сая. кВтц | 373.6 | 372.9 | (0.8) | 99.8% |
| 4 | Түгээх ДЭХ | мян.Гкал | 352.3 | 366.8 | 14.4 | 104.1% |
| 5 | Шугамын алдагдал | хувь | 4.5% | 6.2% | 1.7% | 73.2% |
| 6 | Борлуулсан ЦЭХ | сая. кВтц | 356.7 | 349.7 | (6.9) | 98.1% |
| 7 | Нийт орлого | сая.төг | 111,070.0 | 109,463.8 | (1,606.2) | 98.6% |
| 8 | Нийт зардал | сая.төг | 136,710.0 | 137,219.4 | 509.4 | 100.4% |
| 9 | Татварын дараах цэвэр ашиг / алдагдал / | сая.төг | (25,640.0) | (27,755.6) | (2,115.6) | 108.3% |
| 10 | БО-ын 1 төгрөгт ногдох зардал | төг | 1.231 | 1.254 | 0.023 | 101.8% |
| 11 | Нийт авлага | сая.төг | 4,154.5 | 3,916.700 | (237.8) | 94.3% |
| 12 | Нийт өр төлбөр | сая.төг | 240,173.8 | 243,407.3 | 3,233.5 | 101.3% |
| 13 | Нийт ажилтан | сая.төг | 740.0 | 720.0 | (20.0) | 97.3% |
| 14 | Нийт цалингийн сан | сая.төг | 33,807.8 | 33,582.6 | (225.2) | 100.7% |
| 15 | Жишмэл түлшний хувийн зарцуулалт: ЦЭХ | гр/кВтц | 543.6 | 538.5 | (5.1) | 100.9% |
| | Жишмэл түлшний хувийн зарцуулалт: ДЭХ | кг/Гкал | 191.0 | 190.1 | (0.9) | 100.5% |
| 16 | Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ | сая.төг | 4,107.9 | 3,888.2 | (219.8) | 94.7% |

# СИСТЕМИЙН ХЭМЖЭЭНД ОРЛОГО, ЗАРДАЛ, АЛДАГДАЛ

**109,463.8 сая.төг**

НИЙТ ОРЛОГО

**137,219.4 сая.төг**

ЗАРДАЛ

**27,755.6 сая.төг**

АЛДАГДАЛ

-

Компанийн 2025 оны дамжуулалтын алдагдлын хувь хэмжээг ЭХЗХ-ны 2024 оны 675 дугаар тогтоолоор 4.55% байхаар баталсан бөгөөд Хэнтий, Сүхбаатар аймгийг өвлийн их ачааллын үед 110 кВ-ын Чойбалсан–Баруун-Урт–Өндөрхаан шугамаар тэжээсэнтэй холбоотойгоор шугамын ачаалал нэмэгдэж, шугамын алдагдал 1.7 пунктээр өссөн.

Тайлант хугацаанд компани 109,463.8 сая төгрөгийн орлого, 137,219.4 сая төгрөгийн зардалтай ажиллаж, татварын дараах 27,755.6 сая төгрөгийн алдагдалтай гарсан бөгөөд үүнд "Чойбалсангийн ДЦС-ыг 50 МВт-ын шинэ станцаар өргөтгөх төсөл"-ийн зээлийн валютын ханшийн зөрүүнээс үүдэлтэй 16.3 тэрбум төгрөгийн бодит бус алдагдал болон цахилгаан эрчим хүчний түгээлтийн хязгаарлалтаас шалтгаалсан 2,431.7 сая төгрөгийн борлуулалтын орлогын бууралт голлон нөлөөлсөн.




**БОЛОВСРУУЛСАН ЦЭХ /сая.кВт.ц/**




**ТҮГЭЭСЭН ЦЭХ /сая.кВт.ц/**




**ТҮГЭЭСЭН ДЭХ /мян.ГКал/**

## ЦАХИЛГААН АЧААЛАЛ /МВт/




## ДОТООД ХЭРЭГЦЭЭНИЙ ЦЭХ /хувь/




## ТҮЛШНИЙ ХУВИЙН ЗАРЦУУЛАЛТ




НИЙТ ОРЛОГО /сая.төг/
120,000.0
100,000.0
80,000.0
60,000.0
40,000.0
20,000.0
-
51,536.6
52,167.5
73,550.3
80,687.5
109,463.8
2021
2022
2023
2024
2025


НИЙТ ЗАРДАЛ /сая.төг/
160,000.0
140,000.0
120,000.0
100,000.0
80,000.0
60,000.0
40,000.0
20,000.0
-
50,442.8
57,638.2
68,159.3
87,711.4
137,219.4
2021
2022
2023
2024
2025


АШИГ, АЛДАГДАЛ /мян.төг/
10,000.0
5,000.0
-
(5,000.0)
(10,000.0)
(15,000.0)
(20,000.0)
(25,000.0)
(30,000.0)
1,047.6
(5,470.7)
4,879.1
(1,892.4)
(27,755.6)
2021
2022
2023
2024
2025

# ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ

Цахилгаан эрчим хүчний **ХЭМНЭЛТ**

**585,203**

кВт.цаг

Дулааны эрчим хүчний **ХЭМНЭЛТ**

**5544**

Гкал

Мөнгөн дүнгийн шууд **ХЭМНЭЛТ**

**263,7**

сая.төг

Болзошгүй **ЗАРДЛААС СЭРГИЙЛСЭН**

**45,8**

сая.төг

**Тайлант хугацаанд тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээ, технологийн горимыг оновчтой болгосноор эрчим хүч болон зардлын хэмнэлтийг дараах байдлаар хангаж ажиллав.**

—

БКЗ-75-39 ФБ зуухны ДН-24 маркийн утаа сорогчийн ажлын дугуйн 32 ширхэг лопадкаг дотоод нөөц бололцоонд тулгуурлан 4.2 сая төгрөгөөр үйлдвэрлэж, шинээр худалдан авахад шаардагдах 50.0 сая төгрөгийн зардлыг орлуулснаар 45.8 сая төгрөгийн зардал хэмнэв.

—

Турбогенератор №1–4-ийн конденсаторын хөргөлтийн хэсгийн цэвэрлэгээг тогтмол хийснээр уурын хувийн зарцуулалтыг 0.2–0.6 тн/МВт.цаг-аар бууруулж, вакуумыг 0.08–0.15%-иар сайжруулан, жилд 447.3 тн жишмэл түлш, 184,653 кВт.цаг цахилгаан эрчим хүч хэмнэв

—

Үндсэн бойлер-1 болон туслах бойлер-1,2-ын зүрхэвчийг хугацаанд нь цэвэрлэснээр дулаан солилцоо сайжирч, халаах уурын зарцуулалт 0.08 кг/кВт.цаг-аар буурч, 156,226 кВт.цаг цахилгаан эрчим хүч хэмнэв

—

Дробилька корпусын орчны температурын хяналтыг сайжруулж, 16°C-ээс дээш үед дулаацуулгын тенийг унтраах горим нэвтрүүлснээр жилд 4,934 кВт.цаг цахилгаан эрчим хүч, 1.41 сая төгрөгийн зардал хэмнэв.

—

Үйлдвэрийн гадна, дотор гэрэлтүүлгийн асалтын хугацааг улирлаар тохируулснаар жилд 41,245 кВт.цаг цахилгаан эрчим хүч, 10.76 сая төгрөгийн зардал хэмнэв.

—

Мазутын насос №2-т давтамж хувиргуур суурилуулж, хөдөлгүүрийн шинэчлэл хийснээр ачааллыг 2.63 кВт-аас 1.28 кВт болгон бууруулж, 1,539 кВт.цаг цахилгаан эрчим хүч, 0.44 сая төгрөгийн зардал хэмнэв.



# Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалт

—

Манай компани 2025 онд үндсэн ба туслах тоноглол их, дунд засварыг батлагдсан графикт хугацаанд нь чанартай гүйцэтгүүлэх, тоног төхөөрөмжийн урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт урсгал засвар, ааварийн эвдрэл, гэмтлийг тухай бүр шуурхай арилгах ажлыг зохион байгуулалтаар хангаж гүйцэтгэлийн хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллалаа. Их засварын ажлын гүйцэтгэл 100 хувийн биелэлттэй байна.

| д/д | Тоноглол | Засварын | Төвөлөсөн хөрөнгө /сая.төг/ | | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|---|
| | | | төсөв | Тодотгол | /сая.төг/ |
| 1 | Үндсэн | Их засвар | 1,847.2 | 1,197.2 | 1,194.9 |
| 2 | Туслах | Их засвар | 78.0 | 78.0 | 59.8 |
| Дүн | | | 1,925.2 | 1,275.2 | 1,254.7 |
| 3 | Хөрөнгө оруулалт | | 2,668.3 | 2,504.0 | 2,318.8 |
| 4 | ТЗБАХ | | 168.8 | 168.8 | 156.2 |
| 5 | Барилга | | 160.0 | 160.0 | 158.4 |
| | НИЙТ ДҮН | | 4,922.2 | 4,107.9 | 3,888.2 |

**2025-2026 оны өвлийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөөний талаар:**

—

Компанийн хэмжээнд 2025-2026 оны өвлийн бэлтгэл хангах зорилгоор 12 хэсэг нэгжийг хамруулан 69 нэр төрлийн ажил тусгаж, төлөвлөгөө гарган гүйцэтгэл 100% -тай байна.




**МАЗУТ 300тн**




**ДАВС 220тн**



**АВААРИЙН НӨӨЦ 319 төрөл 87%**

## Турбогенератор №1 их засвар:

Турбины их засварын ажлын хүрээнд 1,2 дугаар холхивчинд напловка разъем болон чиглүүлэгчүүдийг засварлаж голын хүзүүний диаметрд тохируулж токарийн суурь машин дээр зоруулж шайбердаж тохируулсан, даралтын үеүүдийн голын нягтруулагчуудыг сэргээх засварлах, генератор болон турбины роторын муфтны нүүрний цохиог арилгаж, 0,01-0,02 мм болгож шайбердаж тааруулав. 2025 оны 06-р сарын 16-ны өдөр Турбогенератор №1 ажиллагаанд явуулж шаардлагатай параметр гарган хэмжилт туршилт хийгдэж акт формуляр үйлдэх, техникийн паспортад баяжилт хийх зэрэг шаардлагатай ажлуудыг шат дараатай хийж ажиллагаанд хүлээн авсан.





## Зуух №5 уур халаагчийн 1,2-р үе солих их засвар:

Зуух №5 ийн уур халаагчийн 1,2-р үе солих засварын ажлыг 2025 оны 06 сарын 02 ны өдөр наряд нээж эхлүүлсэн. Ажлын хувьд уур халаагч 1, 2 үе, орох гарах коллектор, уур хөргөгчийн коллекторуудыг бүрэн сольж, уур халаагчийн хананы өрлөг, коллекторуудын өрлөг дулаалга, таазны бетон болон ажлын ээлхүүнд заагдсан бусад өрлөг дулаалгын ажлыг бүрэн хийсэн. 2025 оны 07 сарын 30 нд зуухыг 40 ата даралтаар усан шахалт хийж зуухыг бэлтгэлд оруулсан.





## 2025 оны хөрөнгө оруулалтаар хийсэн техник, технологийн шинэчлэл.

—

2025 оны хөрөнгө оруулалтаар 38,6 сая төгрөгөөр турбины дунд даралтын хэсэгт ТҮ-50 масло цэвэрлэх төхөөрөмжийг суурьлуулан ашиглалтын заавар батлуулан гаргаж ажилчдад танилцуулан турбогенератор №1,2-ын маслыг цэвэрлэн ажиллагаанд тогтмол ашиглаж байна. Ашигласны үр дүнд турбины маслын агуулах усны хэмжээ багасав.



—

2025 хөрөнгө оруулалтаар 79,3 сая төгрөгөөр Турбогенератор №1,2-ын хяналт удирдлагын системийн программ хангамжийг шинэчлэх ажил төлөвлөн зохион байгуулж “ПОВЕРТҮҮЛ” ХХК –нь 2025 оны 04 сарын 17 ний өдөр 1 нэр төрлийн 5 ширхэг Спеквьюв (SpecView 3.1) программ хангамж нийлүүлсэн.






—

2025 оны хөрөнгө оруулалтаар “Чойбалсан- Баруун урт” 110кВ-ын ЦДАШугамын засварын ажилд 519,8 сая төгрөгөөр 15,8 км цахилгаан дамжуулах агаарын шугамд 3 фазын дамжуулагч утас солих, чичиргээ намдаагч хийх мөн аянгын хэц болон дамжуулагчийн баригч лочки, түгжээнд засварын ажил хийсэн.





—

2025 оны компаний хөрөнгө оруулалтаар 68 сая төгрөгөөр нийлүүлэгдсэн 110кВ-ын элегаз таслуурыг Чойбалсан 110/35/6кВ-ын ИХБ-ийн 110кВ-ын секц холбогч таслуураар суурилуулах угсралтын ажлыг туршилт тохируулга хийж Чойбалсан 110/35/6кВ-ын ИХБ-д холбох ажлыг хийж 110кВ-ын трансформатор №1,2 зэрэгцээ болон тусдаа горимоор ажиллах, шуурхай сэлгэн залгалтын үед гэмтлийг зааглаж түргэн шуурхай устгах зэрэг боломж бүрдсэн томоохон ажил болсон.




# ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРҮҮЛ АХУЙ

—

2025 онд үйлдвэрийн орчин нөхцлийг сайжруулах, ажилтнуудыг ажлын байран дахь осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөл бусад эрсдлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр төлөвлөгөө гарган ажиллаж байна.

—

ХАБЭА-н шаардлага стандарт, бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үүднээс жилийн ажлын төлөвлөгөө гарган ажиллаж шаардагдах хөрөнгийг хуулийн дагуу компанийн жилийн төсөвт 985,3 сая гаруй төгрөгийг тусгуулан батлуулан ажиллаж байна.

—

Үйлдвэрийн орчин ажлын байрны нөхцлийг сайжруулж тодорхой ахиц дэвшил гаргуулах, аюул осолгүй ажиллах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор цех, хэсгүүдэд ХАБЭА-н байдалд тавих III шатны хяналтын үзлэгийг жилдээ 2 удаа мөн өвлийн бэлтгэл ажлыг шалгах комисс намар удирдамж гарган бүх цех нэгж, хэсгүүдээр явж ажиллаж хэвшсэн.

—

2025 онд манай компани үйлдвэрлэлийн осолгүй ажилласан ба өнөөдрийн байдлаар осолгүй ажилласан хоногийн тоо 745 байна.

# Аюулгүй ажиллагааны чиглэлээр хийгдсэн ажил

Компанийн үйл ажиллагаанд ХАБЭА-н хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, үйлдвэр, дэд станц, шугам тоноглолын техникийн аюулгүй байдлыг хангаж, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, компанийн технологийн үйл ажиллагаанд дотоодын хяналт шалгалт хийж, зөвлөмж, дүгнэлт гарган хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.

Үйлдвэрлэлийн ХАБЭА-н орчин нөхцөлийг сайжруулах, ажилтнуудыг ажлын байран дахь осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөл бусад эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр жилийн ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллалаа.

| д/д | Дасгал зааварчилгааны төрөл | | | | 2021 | 2022 | 2023 | 2024 | 2025 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Зааварчилгаа авсан хүний тоо | Урьдчилсан | | | 288 | 422 | 295 | 446 | 276 |
| 2 | | Анхан шатны | | | 135 | 267 | 179 | 241 | 444 |
| 3 | | Давтан | Ээлжит | Өдөр тутмын | 47667 | 96129 | 91419 | 86444 | 93504 |
| 4 | | | | Сарын давтан | 2672 | 4762 | 5179 | 5367 | 7736 |
| 5 | | | Ээлжит бус | | 3491 | 5638 | 4790 | 6038 | 7069 |
| 6 | | Тухайлсан | | | 3782 | 7515 | 7722 | 8417 | 9412 |
| 7 | Дасгал | АЭД | Дасгалын тоо | | 133 | 283 | 399 | 593 | 87 |
| 8 | | | Хамрагдсан хүний тоо | | 1862 | 3730 | 3165 | 2579 | 2251 |
| 9 | | ГЭД | Дасгалын тоо | | 42 | 88 | 197 | 247 | 36 |
| 10 | | | Хамрагдсан хүний тоо | | 1368 | 2926 | 1524 | 2391 | 1305 |

"ДБЭХС" ТӨХК-ийн хэмжээнд 2025 онд үйлдвэрлэлийн осол болон осол дөхсөн тохиолдол бүртгэгдээгүй байна.

| д/д | Огноо | Үйлдвэрийн осол гарсан тоо | Үйлдвэрийн осолд өртсөн хүний тоо | Гэмтлийн хэлбэр |
|---|---|---|---|---|
| 1 | 2021 | 0 | 0 | - |
| 2 | 2022 | 1 | 1 | хүнд |
| 3 | 2023 | 0 | 0 | - |
| 4 | 2024 | 1 | 1 | Нас барсан |
| 5 | 2025 | 0 | 0 | |

# Хяналт, үзлэг






**93,504**

Өдөр тутмын зааварчилгаа

2025 оны 12 дугаар сарын байдлаар

**Зааварчилгаа**

| | |
|---|---|
| Сарын давтан зааварчилгаа | **7,736** |
| Ээлжит бус зааварчилгаа | **7,069** |
| Тухайлсан заавpчилгаа | **9,412** |

—

Компаний ерөнхий инженерийн нэрэмжит үзлэгийг хагас жилд 1 удаа зохион байгуулдаг ба сүүлийн хагас жилийн үзлэгийг 2025.08.25-ны өдөр цехүүдийн ӨДС-ын хэсэгт хийсэн. Үзлэгээр илэрсэн зөрчил дутагдлуудыг хугацаатай албан даалгавар өгч арилгуулан ажиллаж байна.

ХАБЭА-н 3 дахь шатны хяналтын үзлэгийг 2025 оны 6 сар болон 12 сард зохион байгуулж 8 цех, 1 салбар, 1 хэлтэс, 2 нэгж хэсэгт компанийн захиргаа болон ҮЭХ-ны хамтарсан комисс хяналт үзлэгийг зохион байгуулан ажиллаж байна.

—

2025 онд үйлдвэрийн обьектод ажил гүйцэтгэх ажилтнуудын ажлын аюулгүй байдлыг хариуцагч, тусгай үүрэг хүлээгчийн эрх олгох ээлжит бус сургалт, мөн шинээр ажилд орсон ажилтанд мэргэжил олгох сургалтууд зохион байгуулсан.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, ажлын байрны эрүүл ахуйг хангах, ажилтнуудыг аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэн хамгаалах, тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулах зорилгоор цех, хэсгүүдэд ХАБЭА-гийн байдалд тавих III шатны хяналтын үзлэгийг хагас жил тутамд нэг удаа зохион байгуулдаг. Энэ хүрээнд комисс батлагдсан удирдамжийн дагуу ажиллан, цех, нэгжүүдийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлд хяналт шалгалт хийсэн.



—

### Гал, гамшгийн чиглэлээр хийгдсэн ажил

Компанийн галын аюулгүй байдлыг хангах, гал түймрийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор гал түймрийн улсын хяналтын гэрээт байцаагчийг ажиллуулж байна. Жил бүр гал унтраах анхан шатны багаж, хэрэгслийг шаардлагатай тоо хэмжээгээр худалдан авч, цех, нэгжүүдэд нөхөн хангалтаар олгон, ажлын байруудад байршуулж бэлэн байдлыг ханган ажиллаж байна.

Тайлант хугацаанд галын аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр өдөр тутмын болон төлөвлөгөөт хяналт шалгалтыг нийт 122 удаа зохион байгуулж, 87 зөрчил илрүүлсэн. Үүнээс 79 зөрчлийг газар дээр нь арилгуулж, үлдсэн 8 зөрчилд хугацаатай албан шаардлага, мэдэгдэл хүргүүлэн, зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээ авч ажилласан.

Компанийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу ажилтнуудад галын аюулаас урьдчилан сэргийлэх, гал унтраах анхан шатны мэдлэг, чадвар олгох сургалтыг гал түймрийн улсын хяналтын гэрээт байцаагч болон орон нутгийн Онцгой байдлын газар, гал унтраах ангитай хамтран зохион байгуулж байна. 2025 онд нийт 236 ажилтныг сургалтад хамруулсан.

Засгийн газрын 2017 оны 67 дугаар тогтоолоор жил бүрийн 3 дугаар сарын дөрөв дэх долоо хоногийн лхагва гарагийг “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр” болгох шийдвэрийн дагуу жил бүр гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дадлага, сургуулилт хийж бэлэн байдал хангаж ажилласан.



# Эрүүл ахуйн чиглэлээр хийгдсэн ажил

—

ЭМНХ-ны сайдын 2000 оны 171 дүгээр тушаал болох “Химийн хорт бодистой харьцаж ажилладаг ажилтанд олгох хор саармагжуулах хүнсний бүтээгдэхүүний жагсаалт”-ын дагуу 102 ажилтанд ажлын өдөр бүр хор саармагжуулах хүнсний бүтээгдэхүүн олгож байна. Үүнд дотоодын үйлдвэрийн хатаасан аарц болон эрүүл мэндийн бэлдмэлийг тогтмол олгож хэвшсэн болно.










—

ХАБЭА-н тухай хуулийн 14 дүгээр зүйл, Эрүүл мэндийн сайдын 2015 оны 340 дүгээр тогтоолд тус тус заасны дагуу 2025 оны “Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх болон хугацаат үзлэг”-ийг зохион байгуулсан. Үзлэгт 574 ажилтан хамрагдаж, 96,5%-тай байна.







—

Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор үйлдвэрт тоостой нөхцөлд ажилладаг ажилтнуудад хүчилтөрөгчийн коктейлийг өдөрт 1 удаа олгож байна.





—

Цех, нэгж бүрд артерийн даралтны аппарат байршуулан ажилтануудынхаа артерийн даралтыг тогтмол хянаж ажилд гаргадаг. Мөн улирал бүр анхан шатны тусламжийн эмийн сангийн хайрцагт нөхөн хангалт хийж шаардлагатай үед эмчийн заавраар авч хэрэглэж байна.

—

Жил бүр ариутгал халдваргүйтгэлийн ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран хийдэг ба энэ онд “Эгэл-Альфа” ХХК-тай ариутгал халдваргүйтгэлийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулж эмнэлэг, цайны газар, ажлын болон ахуйн байруудад шавьж, мэрэгчийн устгал хийлгэх хуваарь гарган хуваарийн дагуу хийлгэлээ.







# Байгаль орчин

—

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголд тусгагдсан орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хянах ажлыг зохион байгуулж, холбогдох шинжилгээнүүдийг гэрээт байгууллагаар гүйцэтгүүлсэн.

Үүнд агаар, хөрс, ус, хаягдал усны шинжилгээг тогтмол хийж, үнсэн сан болон Хэрлэн голын уснаас дээж авч химийн болон био идэвхт үзүүлэлтүүдийг тодорхойлуулан дүгнэлт гаргуулж ажилласан. Шинжилгээний үр дүнгээр агаар, хөрс, усны үзүүлэлтүүд нь холбогдох стандартын шаардлагаас хэтрээгүй .





—

Байгаль орчны аудитын дүгнэлтээр үйл ажиллагааны нийцэл 85.6 хувь, үл нийцэл 14.4 хувьтай үнэлэгдэж, илэрсэн зөрчлийг арилгах нөхцөлтэйгээр төслийг цаашид хэвийн үргэлжлүүлэх боломжтой гэж дүгнэгдсэн.

Мөн зуухнаас ялгарах утааны найрлагад агуулагдах бохирдуулагч бодисын хэмжилтийг тогтмол хийж, холбогдох стандарттай харьцуулан хяналт тавин ажиллаж байна.

Цацрагийн аюулгүй байдлыг хангах хүрээнд үнсэн сан болон хаягдал үнсэнд цацрагийн шинжилгээ хийлгэх ажлыг эхлүүлсэн бөгөөд шинжилгээний дүн хүлээгдэж байна. Өмнөх жилүүдийн дүнгээр хаягдал үнсийг барилгын зориулалтаар ашиглахгүй байх дүгнэлт гарсан.




–

Ус ашиглах гэрээний 2.12-т заасан нөхцлийн дагуу 2025 оны 3 дугаар сарын 24 нд Дорнод аймгийн Байгаль орчны газартай хамтран олон улсын “Ойн өдөр”, дэлхийн “Усны өдөр”-ийн хүрээнд зохион байгуулсан “Нээлттэй хаалганы өдөрлөг”-т байгууллагын үйл ажиллагааг сурталчилж оролцов.

–

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1-т зааснаар 2023 онд хийлгэсэн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголд эрх бүхий мэргэжлийн байгууллагаар байгаль орчны аудит хийлгэж “ДБЭХС” ТӨХК-ийн дулааны цахилгаан станцын үйл ажиллагаанд хийсэн байгаль орчны төлөвлөгөөт аудитын тайлан, дүгнэлтийг хүлээн авсан. Байгаль орчны аудитын дүгнэлтэд:

“ДБЭХС” ТӨХК-ийн Дорнод аймгийн Хэрлэн сумын нутагт орших “Дулааны цахилгаан станц” төслийн Байгаль орчны төлөвлөгөөт аудитын ажлын үр дүнг үндэслэн дараах нэгдсэн дүгнэлтийг өгч байна.

Үүнд:

1. Байгаль орчны аудитын нэгтгэл, нийцэл, гүйцэтгэлийн үр дүнгийн хэрэгжилтийг үзэхэд хяналтын 78 шалгуур үзүүлэлтийн “Нийцэл” 85,6%, “Үл нийцэл” 14,4% байна.

2. Тус тайланд тусгасан гүйцэтгэлийн үр дүн, дүгнэлт, зөвлөмж, байгаль орчны аудитаар илэрсэн үл нийцлийг залруулах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж ажиллах нөхцөлтэйгөөр уг төслийг “Цаашид хэвийн үргэлжлүүлэх боломжтой” гэж дүгнэв.



ХАЯГДАЛ УС ХАЯХ, ЗАЙЛУУЛАХ
ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар: 01

... 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн хаягдал ус хаях, зайлуулах 48 тоот ...

... 388,200 м³ хаягдал усыг “Хүрээлэн байгаа орчин, Усны чанар, хаягдал ус, ерөнхий шаардлага MNS 4943:2015”, “Хүрээлэн байгаа орчин, усны чанар, Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус, ерөнхий шаардлага MNS 6561:2015” стандартаар тогтоосон норматив шаардлагад нийцүүлэн хаях, зайлуулах зөвшөөрлийг ...

Зөвшөөрлийн бичиг олгосон:

Тамга

2021 оны 04-р сарын 27-ны өдөр



СУНГАЛТ

| Сунгалт хийсэн шийдвэр | Огноо | Гарын үсэг / тамга |
| --- | --- | --- |
| [illegible] | 2022. 05. 09 | |
| [illegible] | 2023. 12. 27 | |
| [illegible] | 2024. 05. 07 | |
| [illegible] | 2025. 06. 16 | |

# ЦАХИЛГААНААР ЗОХИЦУУЛАЛТТАЙ ТҮГЭЭХ, ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2025 оны нийт түгээлт **ТӨЛӨВЛӨЛТ**

**394.7**

сая.кВт.цаг

2025 оны нийт түгээлт **ГҮЙЦЭТГЭЛ**

**372.8**

сая.кВт.цаг



Системийн нийт **АЛДАГДАЛ**

**23.1**

сая.кВт.цаг

**6.2%**

## 2025 ОНЫ ТҮГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОН ГҮЙЦЭТГЭЛ /сая.кВт.ц/




## "ДБЭХС" ТӨХК-ийн нийт түгээлт, борлуулсан ЦЭХ, техникийн болон техникийн бус алдагдлын судалгаа /биетээр мян.кВт.ц/



## Шугамын алдагдал

Цахилгаан эрчим хүчний түгээлтийн шугамын алдагдал Эрчим хүчний зохицуулах хорооноос тогтоосон хувь хэмжээнээс 1.7 пунктээр өссөн.




## Дамжуулах сүлжээний алдагдал өссөн шалтгаан:

2025–2026 оны өвлийн их ачааллын горимын үед Хэнтий болон Сүхбаатар аймгийн хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр тасралтгүй хангах зорилгоор ачааллыг 110 кВ-ын (Чойбалсан–Баруун-Урт–Өндөрхаан) цахилгаан дамжуулах шугамаар дамжуулан нийлүүлсэн. Үүний улмаас тухайн шугамын ачаалал нэмэгдэж, дамжуулалтын техникийн алдагдлын хэмжээ өссөн.

## Борлуулалтын алдагдал өссөн шалтгаан:

Дорнод болон Сүхбаатар аймгийн гэр хорооллын айл өрхийн цахилгааны тарифтай холбоотойгоор тоолуурын батарей солих, программ уншуулж цагийн тохиргоо хийх ажлыг гүйцэтгэх явцад техникийн нөхцөл үүссэн. Тодруулбал, гэр хорооллын нийт 1,608 ширхэг тоолуурт өглөөний 06:00–09:00 цагийн тарифын тохиргоо хийх явцад хэрэглэгчийн цахилгаан хэрэглээг 2–10 хоногийн хугацаанд задгай холболтоор түр бүртгэн, дараа нь нөхөн бичилт хийсэн. Үүний улмаас 11–12 дугаар сарын бичилтийн зөрүү үүсэж, борлуулалтын алдагдлын хэмжээ өсөхөд нөлөөлсөн.

—

## Техникийн нөхцөл олголтын талаар

Цахилгаан эрчим хүчний техникийн нөхцөл олголтыг хэрэглэгчдийн хэрэглээний шинж чанар, ачааллын хэмжээ, суурилагдсан хүчин чадлыг нарийвчлан судалж, түгээх сүлжээний нэвтрүүлэх чадвар, техникийн боломжийг харгалзан олгож байна. Мөн орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмж ашиглах, хэрэглэгчийн шугам сүлжээ, дэд станцыг стандартын дагуу угсрах, модон тулгуурыг төмөр бетон тулгуураар үе шаттайгаар солих шаардлагыг техникийн нөхцөлд тусган хэрэгжилтийг хангуулж ажилладаг.

Тайлант хугацаанд компанийн эзэмшлийн 6–35 кВ-ын хүчдэлийн түвшинд цахилгаан эрчим хүчинд холбогдохоор нийт 761 хэрэглэгч техникийн нөхцөл хүссэн албан хүсэлт ирүүлснээс 649 хэрэглэгчид техникийн нөхцөл олгож, холбогдох үйлчилгээний хураамжид 48,484.5 мянган төгрөгийг компанид төвлөрүүлсэн байна.

2025 оны байдлаар 6–35 кВ-ын түвшинд олгогдсон техникийн нөхцөлүүдийн хэрэгжилтийн хүрээнд тодорхой тооны хэрэглэгчид эрчим хүчний системд амжилттай холбогдож, цахилгаан хангамжид орсон.




—

## Эрчим хүчний борлуулалт

2025 онд 349.7 сая кВт.цаг цахилгаан эрчим хүч хэрэглэгчдэд борлуулж өмнөх жилээс 52.8 сая кВт.цаг буюу 17.8 хувиар өсч, төлөвлөгөөнөөс 6.9 сая кВтв.цаг буюу 1.9 хувиар буурсан байна. Сүүлийн 5 жилд дунджаар 293.8 сая кВт.цаг цахилгаан эрчим хүч борлуулж хэрэглээний өсөлт 7.3 хувь байна



# 2025 ОНЫ ОРЛОГО ЦУГЛУУЛАЛТ

Нийт хийгдсэн БИЧИЛТ

**119,775.63**

сая.төгрөг

Цугларсан ОРЛОГО

**119,058.64**

сая.төгрөг

ГҮЙЦЭТГЭЛ **99,4%**






—

## Эрчим хүчний авлага

2025 оны эхэнд 1,583.17 сая төгрөгийн цахилгаан эрчим хүчний авлагатай байснаас оны эцэст 2,257.7 сая төгрөгийн авлагатай болж 674.53 сая төгрөгөөр буюу 42.6 хувиар өссөн.

**Эрчим хүчний авлагын ангилал**




| Төрөл | Авлага | Хувь |
|---|---|---|
| Төсөв | 205.5 | 9.1% |
| ҮААНБ | 1,082.8 | 48.0% |
| Айл өрх | 969.5 | 42.9% |
| Нийт дүн | 2,257.7 | 100% |

# ГЭР ХОРООЛЛЫН АЙЛ ӨРХИЙН ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФЫН ХӨНГӨЛӨЛТ



–

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 199 дүгээр тогтоолоор баталсан “Гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлэх журам”-ыг үндэслэсэн ЭХЗХ-ны тогтоолын дагуу “ДБЭХС” ТӨХК-ийн хэмжээнд давхардсан тоогоор нийт 8358 хэрэглэгч гэр хорооллын өглөө, шөнийн хөнгөлөлт эдэлсэн байна.

Гэр хорооллын тарифт тоолууртай өрхийн 2025 онд шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны тарифт үзүүлсэн хөнгөлөлтийн гүйцэтгэл:

| д/д | Огноо | Нийт хөнгөлөлт | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Хэрэглэгчийн тоо | ЦЭХ-ний хэрэглээ, мян. кВт.цаг | Дүн /НӨАТ ороогүй/, сая. төг | Дүн /НӨАТ орсон/, сая. төг |
| 1 | 2025 оны 01 сарын гүйцэтгэл | 2,428 | 1,272.2 | 155,7 | 171,3 |
| 2 | 2025 оны 02 сарын гүйцэтгэл | 2,501 | 1,399.8 | 195,0 | 214,5 |
| 3 | 2025 оны 03 сарын гүйцэтгэл | 2,519 | 1,851.1 | 285,2 | 313,7 |
| 4 | 2025 оны 11 сарын гүйцэтгэл | 2,968 | 838.7 | 130,3 | 143,3 |
| 5 | 2025 оны 12 сарын гүйцэтгэл | 3,046 | 1,789.1 | 268,4 | 295,2 |
| Дүн | | | 7,150.89 | 1,034,7 | 1,138,2 |

–

Өвлийн хүлэмжийн аж ахуйн 2025 онд шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны тарифт үзүүлсэн хөнгөлөлтийн гүйцэтгэл:

| № | Үзүүлэлт | Хэрэглэгч тоо | Шөнийн хэрэглээ, мян.кВт.ц | | Цахилгааны тариф, төг/кВт.ц | Хөнгөлөлт дүн, мян.төг /НӨАТ-гүй/ | Хөнгөлөлт дүн, мян.төг /НӨАТ-тай/ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 5000 кВт.ц-аас ихгүй хэрэглээ | Нийт | 5000 кВт.ц-аас ихгүй хэрэглээг | | |
| 1 | 2025 оны 1 сар | 1.0 | 3.1 | 3.1 | 136 | 426.5 | 469.1 |
| 2 | 2025 оны 2 сар | 1.0 | 3.8 | 3.8 | 136 | 511.0 | 562.0 |
| 3 | 2025 оны 3 сар | 1.0 | 3.4 | 3.4 | 136 | 464.6 | 511.0 |
| 4 | 2025 оны 4 сар | 1.0 | 2.9 | 2.9 | 136 | 394.4 | 433.8 |
| 5 | 2025 оны 11 сар | 1.0 | 0.6 | 0.6 | 136 | 80.9 | 89.0 |
| 6 | 2025 оны 12 сар | 1.0 | 2.3 | 2.3 | 136 | 313.9 | 345.3 |
| | | 1.0 | 16.1 | 16.1 | | 2191.2 | 2410.4 |

—

## Шөнийн тарифын хөнгөлөлт

Монгол Улсын Засгийн газраас агаарын бохирдлыг бууруулах зорилгоор гэр хорооллын айл өрхийн оройн болон шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны тарифт 2017 оноос эхлэн хөнгөлөлт үзүүлж байна. Тус хөнгөлөлт нь жил бүрийн 11 дүгээр сарын 1-нээс дараа оны 4 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл хэрэгжүүлдэг.

Тайлант хугацаанд гэр хорооллын нийт 2,692 хэрэглэгчийн шөнийн цагийн 7,150.89 мянган кВт.ц цахилгаан хэрэглээнд нийт 1,138.2 сая төгрөгийн хөнгөлөлт үзүүлсэн байна.




—

"Гэр хорооллын өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт үзүүлэх журам"-ын дагуу нийслэлийн болон аймгийн төв, арван мянгаас дээш хүн амтай сум, суурин газрын гэр хорооллын тарифт тоолууртай айл өрхийн 100 хувийн хөнгөлөлт үзүүлэх нэг сарын хэрэглээний дээд хязгаарыг 220В-ын хүчдэлийн түвшинтэй хэрэглэгчдэд 1500 кВт.ц, 380В-ын хүчдэлийн түвшинтэй хэрэглэгчдэд 3000 кВт.ц-аар тооцох, мөн өглөөний 06:00-09:00 цагийн хооронд хэрэглэсэн цахилгааны тарифыг 100 хувиар хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажилласан.

—

Нийгмийн халамжийн дэмжлэг зайлшгүй шаардлагатай бага орлоготой ахуйн хэрэглэгчдэд ЭХЗХорооны 2018.10.11-ний №291 тоот тогтоолын хавсралтын 5.3 дах заалт болон ХНХС-ын 2025.06.02-ны №А/135 тоот тушаалаар баталсан босго онооны шалгуур хангасан иргэд хөнгөлөлттэй тарифын гэрээ хийгдсэн. Тайлант онд шинээр 6 бүртгэгдэн, цуцлагдсан 42 нийт 46 хэрэглэгч хөнгөлөлт эдлэж байна.



Байнгын асаргаатай ахмад настан **3**



Нэн ядуу **32**



Олон хүүхэдтэй **1**



Хөгжлийн бэрхшээлтэй **10**

e mongolia Цахим үндэстэн

ЛАВЛАГААГ ҮНДЭСЛЭВ

| Хугацаа | Оны эхэнд | Нэмэгдсэн | Цуцлагдсан | Нийт |
|---|---|---|---|---|
| 2022 он | 129 | 5 | 11 | 123 |
| 2023 он | 123 | 4 | 3 | 124 |
| 2024 он | 124 | 3 | 45 | 82 |
| 2025 он | 82 | 6 | 42 | 46 |

| д/д | Огноо | Нийт олгосон хөнгөлөлт | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Хэрэглэгчийн тоо | Хэрэглээ мян.кВт.ц | Дүн /НӨАТ ороогүй/ сая.төг | Дүн /НӨАТ орсон/ сая.төг |
| 1 | 2021 | 129 | 212.32 | 16.1 | 17.75 |
| 2 | 2022 | 123 | 251.94 | 19.1 | 21.09 |
| 3 | 2023 | 124 | 249.27 | 18.9 | 20.83 |
| 4 | 2024 | 126 | 229.20 | 17.3 | 19.06 |
| 5 | 2025 | 46 | 215.87 | 21.1 | 23.25 |

# ИМПОРТООР АВСАН ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ ТҮГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ



—

Сар тутам эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлтийн балансжилтыг ДЦС-ын гаргалгаа бүрээр тооцож Microsoft EXCEL программ дээр хийгддэг бөгөөд Powerfactory программаар хянан шалгадаг.

“ДБЭХС” ТӨХК-ийн Ульхан, Хавирга боомтуудыг 2016 оны 03 сарын 25-наас Дорнод аймгийн Гаалийн газраас өмчлөл шилжүүлэн хүлээн авсан.

| д/д | Ячейкны нэр дугаар | ТЭЦ-ийн түгээлт | Дамжуулах түгээх сүлжээний ΔW | | Дамжуулан түгээсэн ЦЭХ | ТП-ны ер тоолуурт гарсан ЦЭХ | Бичилт хийсэн ЦЭХ | 0.4 кВ алдагдал | Алдагдал % | Бичилтийн хувь % |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Бодит | Хувь | | | | | | |
| 1 | Ульхан боомт | 112.512 | 0.000 | 0.00 | 122.512 | 122.512 | 124.668 | -2.156 | -1.76 | 101.8 |
| 2 | Хавирга боомт | 324.024 | 0.000 | 0.00 | 324.204 | 324.204 | 302.412 | 21.793 | 6.72 | 93.3 |
| | Нийт импорт | 446.716 | 0.000 | 0.00 | 446.716 | 446.716 | 427.080 | 19.636 | 4.40 | 95.6 |

# ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧ ХЭРЭГЛЭЭ

—

2025 онд дулааны эрчим хүчний хэрэглээнд 366,8 мГкал дулаан түгээж, 368,1 мГкал дулаан борлуулж 6,913.5 сая.төгрөгийн борлуулалт хийж 6,773.6 сая.төгрөгийн орлого цуглуулсан байна.

| Үзүүлэлт | Нэгж | Төлөвлөгөө | гүйцэтгэл | Хувь |
|---|---|---|---|---|
| Түгээсэн дулаан | мГкал | 352,3 | 366,8 | 103 % |
| Борлуулсан дулаан | мГкал | 342,6 | 368,1 | 103 % |
| Борлуулалтын орлого | сая.төг | 6,608.8 | 6,913.5 | 104 % |
| Цуглуулсан орлого | сая.төг | 6,608.8 | 6,773.6 | 102,5% |

—

Чойбалсан хотын төвлөрсөн дулаан хангамжийн системд холбогдсон нийт 9409 хэрэглэгчтэй. ДЭХ-ний төвлөрсөн хангамжийн системд холбогдсон хэрэглэгчийн тоо жилээс жилд нэмэгдэж 2024 онд нийт 8996 хэрэглэгч ДЭХ-д холбогдож байсан бол 2025 онд 9409 хэрэглэгч болж 413 хэрэглэгчээр нэмэгдсэн.

Тарифаар болон эзэмшлийн заагаар аж ахуй нэгж байгууллагын хэрэглэгч болон айл өрхийн хэрэглэгчээр задлаж харуулвал:

| | Аж ахуй нэгж байгууллагын хэрэглэгч | | Ахуйн хэрэглэгч | |
|---|---|---|---|---|
| | Хэмжүүрээр | Задгайгаар | “ДБЭХС”ТӨХК-д | “ДНАА”ОНӨААТҮГ-д |
| Цэгийн тоо | 252 | 684 | 2945 | 5528 |
| | 936 | | 9409 | |

—

